МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.30 № 67

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД Т.АУБАКИР ТАНАА

Төрийн албан хаагчдын цалин
хөлсний бодлогын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн төрийн албан хаагчдын цалин хөлсний бодлогын талаар Танд дараах асуултыг тавьж байна.

1.Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар баримталж буй бодлого, 2027, 2028 онд төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг хэдэн хувиар нэмэгдүүлэх талаар;

2.Боловсролын салбарын багш, ажилчдын цалин хөлсний бүтэц, бүрэлдэхүүний өнөөгийн нөхцөл байдал, цаашид хийх шинэчлэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.НАРАНБАЯР

2026000197